



Canada

Хамтын ажиллагаа сайтай эерэг орчинг бүрдүүлэх нь

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв

Вилл Гау
MERIT төслийн техникийн зөвлөх
2021 оны 3 дугаар сарын 2-ны өдөр

—— Сургалтын зорилт

Дараах чиглэлээр мэдлэг ойлголтоо бататгана:

- Баг хамт олны давуу тал, сайн шинж чанарт тулгуурлан багаар амжилттай ажиллах суурь нөхцлийг бүрдүүлэх;
- Нэгдмэл алсын хараатайгаар багаар үр дүнтэй хамтран ажиллах соёлыг бэхжүүлэх;
- Баг доторх харилцаа, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
- Багийн үйл ажиллагаанд хариуцлага, хамтын ажиллагааны гүйцэтгэх үүргийг тодорхойлох.

— Байгууллагын түвшинд

Та стаканыг дүүрэн эсвэл хоосон гэж харах, эсвэл стаканыг юугаар дүүргэхээс шалтгаалж байгууллагын соёл тодорхойлогддог.

Стаканыг хамт олны *ээрэг дадал зуршил, туршлага, үзэл санаа, сайн туршлагаар* дүүргэцгээе.



—— ЦУНБХТ-ын ү/а-нд нөлөөлөх эерэг нөлөө

- Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлнэ;
- Байгууллагын нэр хүндэд эерэгээр нөлөөлнө;
- Эерэг хандлага бүхий орчинг бүрдүүлнэ;
- Албан хаагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн, харилцан хүндэтгэл бүхий харилцааг бэхжүүлнэ;
- Үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлнэ;
- Үйл ажиллагааны эрсдлийг бууруулна;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг нэмэгдүүлнэ;
- Хөдөлмөрийн зах зээлд нэр хүндтэй ажил олгогч байгууллага байх;
- Мотиваци өгч, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.



—— Итгэлцэл, холбоо харилцаа, нэгдмэл алсын хараа

Хамтын хичээл зүтгэл, үр дүн, багийн ажиллагаанд чиглэсэн соёлыг төлөвшүүлэхэд одоогийн нөхцөл байдлыг хэрхэн өөрчлөх шаардлагатай вэ?

_____ Багийн хөгжлийн үндсэн үе шат

- **Бүрдэлтийн үе**

Багийн гишүүд баг доторх хүн бүрийн онцлог, зан төлөв, харилцаа, ойлголцлын заагийг судалж эхлэнэ.

- **Зөрчилдөөний үе**

Өөрчлөлттэй холбоотой эсэргүүцэл, зөрчилдөөнтэй асуудалтай тулгарна. Тавьсан зорилгын бодит бус байдал, ажлын ачаалал зэрэг асуудал хөндөгдөнө.

- **Тогтворжих үе**

Багийн гишүүд нэг нэгнийхээ сул талд ач холбогдол өгөхөө больж, санал шүүмжийг эерэг байдлаар өгч, дэмжин туслах зан төлөв давамгайлж, нэгнийхээ дутууг нөхнө. Багийн нэгдмэл чанар бүрдэж эхэлнэ.

- **Гүйцэтгэх үе**

Хувь хүний түвшинд өөрчлөлт явагдаж, асуудлыг багаараа шийдэхэд түлхүү анхаарна.

Суралцах дадал, туршлага



—— Хамтын ажиллагаа сайтай багийн үндсэн шинж

- Бие биендээ эерэгээр нөлөөлж, харилцан хамааралтай ажилладаг.
- Хувь хүний хариуцлагыг ухамсарлаж, үйл ажиллагаанд өриймсөг ханддаг.
- Хүн хоорондын харилцаа, багаар ажиллах ур чадвартаа тогтмол анхаарч сайжруулдаг.

— Асуудлыг харах өнцөг

- Эвлүүлдэг тоглоом тоглохтай адил бид эхлээд асуудлын хүрээг тодорхойлдог.
- Дараа нь гол хэсгүүдийг эвлүүлэн тавьдаг.



—— Эерэг өөрчлөлтийн арга яагаад үр дүнтэй вэ?

- Ирээдүйг эерэгээр харах нь биднийг одоо цагт ямар нэгэн үйлдэл хийхэд нөлөөлдөг.
- Аливаа бодит түүх, туршлага зэрэг нь бидний ой санамжийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд асуудлыг илүү утга учиртай, бодитой харахад тусалдаг.
- Аливаад илүү эерэгээр хандах нь өөрчлөлтийг амжилттай өрнүүлэх гол хүчин зүйлсийн нэг юм.
- Хувь хүн, баг хамт олноороо “аливаа” асуудлын хамгийн боломжит хувилбарыг боловсруулж, албан болон албан бус үед ч ашиглаж эхэлнэ.

—— 1:1 ярилцлага

- Сэдвийн дагуу хоёр хүн хоорондоо ярилцлага хийх (нэг хүн 17 минут, нийт 35 минут ярилцах).
- Нэг нэгнийхээ хариулт, туршлагын талаар тэмдэглэл хөтлөх.
- Ярилцлагын үр дүнг дэд бүлэгт хуваагдан, ярилцах.
- Тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй дэд бүлэг 20 минутын турш 1:1 ярилцлагыг нэгтгэн дүгнэнэ.
- Нийтлэг сэдэв, туршлагыг багцлан дүгнэх.

—— Ярилцлагын асуулт

1. Таны хувьд онцгой эерэг үр дүн, нөлөө үзүүлсэн гэж үзэх үйл явдлын талаар ярина уу, яагаад тэр вэ?
2. Ажиллах орчин, нөөц бололцоо, барилга байгууламж, сурч хөгжих боломж, байгууллагын соёл зэрэг зүйлсийн хүрээнд Та юуг өөрчлөхийг хүсч байна вэ?
3. Багаар ажиллахад урам зориг авсан үе тань хэзээ байсан бэ? Тухайн баг юуг, яаж хийж гүйцэтгэсэн бэ?
4. Одоогоос нэг жилийн дараа Төв нь төрийн байгууллагууд дунд хамгийн үр дүнтэй гүйцэтгэлтэй байгууллагаар шалгарсан тохиолдолд ямар ур чадвар хамгийн үр дүнтэй байсан гэж та дүгнэх вэ?

—— Дасгал ажил

Дэд бүлгүүд ярилцсан зүйлээ 5-7 мин хугацаанд нийт АХ-д танилцуулах:

Танилцуулах АХ дараах зүйлсийн хүрээнд танилцуулна:

- *Эерэг үнэт зүйлс;*
- *Эерэг зан төлөв;*
- *Сайн туршлага.*

Тэмдэглэлээ Хүний нөөцийн мэргэжилтэнд илгээх.

— Байгууллагын үнэт зүйлс

<https://pollev.com/esuoba059>

_____ Байгууллагын соёл

Бидний харагдах байдал

**Зан үйл, систем, процесс,
бодлого**

Бидний хийдэг зүйлс

**Хэтийн зорилго, зорилт,
үнэт зүйлс, хүсэл эрмэлзэл,
тэмүүлэл**

Бидний итгэл үнэмшил

Итгэл үнэмшил, төсөөлөл

—— Цаашдын алхам

Байгууллагын зүгээс юу хийх боломжтой вэ?

- Бүх албан хаагчид зайнаас цахимаар ажиллахад тохиромжтой техник, технологийн шийдэлд хөрөнгө оруулах;
- Хамтын ажиллагаанд удирдах АХ тэргүүлэх ач холбогдол өгч үлгэрлэн манлайлах;
- Хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт; шинээр томилогдсон АХ-ийг дадлагажуулах, байгууллагын соёлд дасан зохицуулах хөтөлбөр зэргээс эхлэх;
- Санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг нэмэгдүүлж, холбоо харилцаа сайтай ажиллах.

—— Албан хаагчийн зүгээс хийх боломжтой алхам

- Аливаа өөрчлөлт, шинэ санал санаачлагад нээлттэй хандах;
- Багаар ажиллах харилцааны ур чадвараа дээшлүүлэх;
- Хувийн зохион байгуулалтын чадвараа дээшлүүлж, аливаад үргэлж хариуцлагатай хандах;
- Санал, шүүмжийг эерэг байдлаар өгч, авч сурах.

_____ Багаар амжилттай ажиллах ур чадвар, зан төлөв

- Багийн гишүүн тус бүрийн оролцоо, хувь нэмрийг үнэлдэг;
- Баг дотор итгэлцэл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлдэг;
- Шийдвэрийг эерэг хандлага, арга замаар гаргадаг;
- Нээлттэй харилцаа, шилэн хаалганы бодлогыг хэрэгжүүлдэг;
- Аливаа зөрчилдөөнийг шийдвэрлэдэг;
- Баг хамт олны хамтаар гаргасан шийдвэрийг хүндэлдэг.

—— Хариуцлага

Хариуцлагын гэрээ

- Тодорхой үр дүн, амжилтанд хүрэхийн тулд өөрийн болон хамт олны өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэх зан төлөвийг төлөвшүүлэх зорилготой.

—— Хариуцлагын зарчим

Хариуцлагын гэрээний үр дүн, ач холбогдлыг тодорхойлсноор гэрээний биелэлт, үр дүн сайн байна:

- Албан хаагч бүрт тохируулан үр дүн, ач холбогдлыг таниулах.
- Эерэг, сөрөг үр дүнд хүргэж болно.
- Шагнал, урамшуулал олгох үндэслэлийг сайжруулна.
- Шатлан дэвших үндэслэл болно.
- Хүссэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломж олгоно.

Эсрэгээр

- АТ-ын эрх мэдлийн хүрээнд захиран зарцуулах төсвийг нэмэхгүй.
- Сэлгэх ажиллах, хүссэн үүрэг даалгавараа хийж гүйцэтгэх боломж олгохгүй байж болно.

_____ Хариуцлагын гэрээний эрсдэл

- Албан хаагчид гэрээний биелэлтэд хэт сэтгэл зовинох;
- Гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхэд бэрхшээлтэй тулгарах: Учир нь аливаа нөхцөл байдлаас үл хамаарч гарах үр дүнг ил тод, нээлттэй тодорхойлно.
- Шийдвэр гаргах боломж, эрх мэдэл нэмэгдэхийн хэрээр алдаа гаргах боломж ч нэмэгддэг.
- Хариуцлагын дээш чиглэлтэй урсгалыг бий болгодог

Хариуцлагын гэрээний үр өгөөж

- Үүрэг хариуцлага тодорхой болж, аливаа ажлын гүйцэтгэлээс хүлээх хүлээлт, харилцан хамаарлыг тодорхойлно.
- Албан хаагчийн шийдвэр гаргах, өсч хөгжих боломж нэмэгдэнэ.
- Албан хаагч өөрийн хариуцлагад үл хамаарах асуудлыг өөр аргаар зохицуулах, шилжүүлэх боломж бүрдэнэ.
- Хүссэн үр дүнд хүрэх зорилгоор илүү хариуцлагатай ажиллана.
- Аливаа чиглэл, үйл ажиллагааны зорилгыг сайтар тодорхойлох нөхцөл бүрдэнэ.
- Үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай холбоотой шийдвэрийг илүү үндэслэлтэй гаргах боломж бүрдэнэ.

Асуулт, хариулт





Canada

Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000